



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 277

Улаанбаатар хот

Хорооны 2011 оны 45 дугаар тогтоолоор  
батлагдсан журамд нэмэлт өөрчлөлт  
оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.10, дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Банкны тухай хуулийн 6.2-т заасан үйлажиллагааны зохицуулалтын журам”-ын /цаашид журам гэх/ 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсгийн “... андеррайтерийн үйлчилгээ болон брокерийн үйл ажиллагаа эрхлэхэд Хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журмын 3.1, 3.6, 3.7-д заасан...” гэснийг “...андеррайтерийн болон брокерийн үйл ажиллагаа эрхлэхэд Хорооны 2013 оны 506 дугаар тогтоолоор батлагдсан Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журмын 3 дугаар зүйлд заасан ...” гэж өөрчилсүгэй.
2. Журмын 1.3, 1.7 дахь заалтыг тус тус хүчингүй болгосугай.
3. Журамд нэмэлт, өөрчлөлтийг оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



000311